Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудал

С.Байгальмаа[1], Г.Юмжирдулам[2], Т.Ганцэцэг[3], Л.Насанцэнгэл[4]

[1,3]АШУҮИС, АУС, СЭМ-ийн тэнхим
[2]АШУҮИС,ОУЦС Эмнэлзүйн АУ-ны тэнхим
[4]СЭМҮТ
Цахим хаяг:baigalmaasodnom86@gmail.com, Утас: 99024803

Түлхүүр үг:

Каннабиниод, амфетамин
Сэтгэцийн эмгэг
Магадлан шинжилгээ

Товч утга:

Үндэслэл: Манай улсын хөрш орнуудын хувьд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, холбогдогчийн тоо, эд мөрийн баримтаар хураагдаж буй бодисын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн гаралт, хүн амын эрүүл мэнд, удмын санд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсэхээр байна. Иймд хэрэглэж буй мансууруулах бодисын төрөл, мансууруулах бодис хэрэглэхэд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлс болон эмнэлзүйн илрэлийг судлах нь нэн чухал хэрэгцээтэй байгаа тул бид энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна. **Зорилго:** Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсоны улмаас шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгсдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлыг судлахад оршино. **Судалгааны арга, аргачлал:** Судалгааг агшингийн судалгааны загвараар зорилтот түүврийн аргаар хийж гүйцэтгэсэн бөгөөд асуумж, тусгай боловсруулсан сорил, эмнэл зүйн үзлэг, баримтын судалгааны аргуудыг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулсан болно. **Үр дүн:** Бидний судалгаанд 18-41 насны, эрэгтэй 94, эмэгтэй 12, нийт 106 хүн хамрагдсан ба дундаж нас нь 24,5±6,1 байв. Насны бүлгээр нь авч үзвэл 18-35 насныхан 90.6%-ийг эзэлж байв. Судалгаанд хамрагдсан 106 оролцогчид хамаарах 34 хавтаст хэргийн материалаас үзэхэд судалгаанд хамрагдагсдын 83%-д нь шээсэнд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисыг илрүүлэх шинжилгээгээр мансууруулах бодис хэрэглэсэн нь тогтоогдсон байлаа. Судалгаанд хамрагдагсдын 88.7% нь сэтгэцийн хувьд эрүүл, 11.3% нь мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон. **Хэлцэмж:** Бидний судалгаанд 18-35 насны залуус, тэр дундаа оюутнууд зэрлэг олсны ургамал буюу каннабисыг өөрсдөө түүж бэлтгэн хэрэглэсэн байв. Үүнээс үзэхэд оюутан залуучууд каннабиноидын төрлийн мансууруулах бодисыг хямд төсөр аргаар олж хэрэглэн мансуурч байгааг харуулж байна. Иймээс холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мансууруулах бодис агуулсан ургамлуудыг устгах ажлыг үр дүнтэй явуулах нь маш чухал гэж үзлээ. **Дүгнэлт:** Мансууруулах бодисыг 18-35 насны, гэр бүл болоогүй хүмүүс мансууруулах бодисыг түлхүү хэрэглэж байгаа тул хүүхэд, залууст мансууруулах бодисын талаарх хор уршгийг ойлгуулах нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Үндэслэл: Төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож сэтгэцийн хөөрөл, сэтгэлийн баясал, хий үзэгдэл буюу бусад солио үүсгэх, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг саатуулж булчин сулруулах, нойр хүргэх, тайвшруулах зэрэг үйлчлэлийг үзүүлэх чадвартай, эмнэлгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвэл эмгэг хэрэгцээг бий болгох чадавхтай эм бодисуудыг сэтгэц идэвхит бодис гэж нэрлэдэг.[1] Мансууруулах бодис мөн эсэхийг эмнэлгийн, нийгмийн, хуулийн хэмжүүрээр тогтоодог.[2] Мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисуудыг наркотикууд, сэтгэц идэвхит чадвартай сэтгэц нөлөөт бодисууд, олон улсын хяналтанд ороогүй сэтгэц идэвхит бодисууд гэж гурван бүлэгт ангилан үздэг.[3] Харин өвчний олон улсын 10

дугаар ангилалд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисын төрлийг нь харгалзан 10 дэд бүлэг эмгэг болгон хуваажээ.[4]

НҮБ-ын Мансууруулах бодистой тэмцэх албанаас 2014 оны байдлаар дэлхий дахинд 15-64 насны 250 сая хүн мансууруулах бодис хэрэглэж байна[5] гэж мэдээлсэн бол 2018 онд 269 сая болсон тухай дурджээ.[6] 2010 онд Улаанбаатар хотын өсвөр үе, залуучуудын дунд хийгдсэн судалгаагаар 2.9% нь бензин цавуу, 1.8% нь каннабис, 0.9% нь экстазиг ихэвчлэн найз нөхөдтэйгээ хэрэглэж үзсэн гэжээ.[7] 2011-2012 онд Монгол улсын мансууруулах, сэтгэц идэвхит эм бодис хэрэглэгчдийн дунд хийсэн судалгаагаар 66% нь 1 төрлийн, 34% нь 2-8 төрлийн мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисыг татаж, ууж, сорж, үнэрлэж, тарих зэргээр хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ.[8] Монгол улсад 2014 онд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисын шалтгаант гэмт хэрэгт 62 хэрэгт 144 хүн холбогдон шалгагдаж байсан бол 2018 оны 12 дугаар сарын байдлаар 197 хэрэгт 402 хүн холбогдсон байна.[9]

СЭМҮТ-ийн статистик тоо баримтаас үзвэл мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсоны улмаас шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэсгдийн тоо 2011 онд 11, 2012 онд 110, 2013 онд 41 байсан бол 2018 онд 252 болж өссөн байна.[10]

Мансууруулах бодисын хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн гаралт, хүн амын эрүүл мэнд, удмын санд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсэхээр байна. Иймд хэрэглэж буй мансууруулах бодисын төрөл, хэрэглэхэд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлс болон эмнэлзүйн илрэлийг судлах нь нэн чухал хэрэгцээтэй байгаа тул бид энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.


Зорилго: Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсоны улмаас шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэсгдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлыг судлахад оршино.

Зорилт:

1. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын хэрэглэсэн мансууруулах бодисын төрөл, мансууруулах бодис хэрэглэхэд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлсийг судлах
2. Мансууруулах бодис хэрэглэгчдэд илэрч буй сэтгэц эмгэгийн талаас илрэх шинжүүдийг тодорхойлох

Судалгааны арга, аргачлал: Судалгааг агшингийн судалгааны загвараар зорилтот түүврийн аргаар хийж гүйцэтгэсэн бөгөөд асуумж, тусгай боловсруулсан сорил, эмнэл зүйн үзлэг, баримтын судалгааны аргуудыг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулсан болно. Судалгааны ажлын статистик боловсруулалтыг SPSS 21 программ ашиглан хийж гүйцэтгэсэн. Судалгааны арга зүйг АШУҮИС-ийн Судалгааны Ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар (№2017/3-07) хэлэлцүүлж судалгаа хийх зөвшөөрөл авсан.

Үр дүн: Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсоны улмаас СЭМҮТ-д шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээнд хамрагдахаар ирсэн хүмүүсээс судалгаанд оролцох шалгуур хангасан 106 хүнийг 6 сарын хугацаанд /2017.08.01 – 2018.02.01/ бид судалгаандаа хамруулсан. Бидний судалгаанд 18-41 насны, эрэгтэй 94, эмэгтэй 12, нийт 106 хүн хамрагдсан ба дундаж нас нь 24,5±6,1 байв. Насны бүлгээр нь авч үзвэл 18-35 насныхан 90.6%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний дотор 18-29 насныхан хамгийн их хувийг (77.3%), 36-аас дээш насныхан бага хувийг (9.4%) эзэлж байна Судалгааны үр дүнгээс үзвэл 67% нь гэр бүл болоогүй хүмүүс байв.



Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын шээсэнд илэрсэн мансууруулах бодисын төрөл, хувиар

*MET, AMP - амфетамины төрлийн мансууруулах бодис, THC- тетрагидроканнабиноид, COC- кокайн

Судалгаанд хамрагдсан 106 оролцогчид хамаарах 34 хавтаст хэргийн материалаас үзэхэд судалгаанд хамрагдагсдын 83% (n=88)-д нь шээсэнд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисыг илрүүлэх шинжилгээгээр мансууруулах бодис хэрэглэсэн нь тогтоогдсон байлаа.

Бидний судалгаанд хамрагдагсдын 88.7% (n=94) нь сэтгэцийн хувьд эрүүл, 11.3% нь мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон. Үүнд: 0.9 % (n=1) нь F19.2 Олон төрлийн сэтгэц идэвхит бодисын хамааралтай, 1.9% (n=2) нь F19.1 Олон төрлийн сэтгэц идэвхит бодисын хэтрүүлэн хэрэглээтэй, 1.9% (n=2) нь F15.2 Амфетамины төрлийн сэргээгч бодисын хамааралтай, 2.8% (n=3) нь F15.1 Амфетамины төрлийн сэргээгч бодисын хэтрүүлэн хэрэглээтэй, 0.9 % (n=1) нь F12.2 Каннабиноидын хамааралтай, 2.8% (n=3) нь F12.1 Каннабиноидын хэтрүүлэн хэрэглээтэй байв.

Хүснэгт 1. Мансууруулах бодисуудын сэтгэцэд үзүүлэх нөлөө (Судалгаанд хамрагдагсдын үгээр)

Мансууруулах бодисын хэрэглээний үед сэтгэцийн талаас илэрсэн шинж тэмдгүүд	Хэрэглэсэн мансууруулах бодис: Амфетамин	Амфетамин Каннабиноид Кокайн	Каннабиноид	N
Тайвшрах	8	6	15	29
Сэтгэн бодох чадвар сайжрах	6	0	0	6
Сэтгэл өөдрөг болж, хөөрч баясах	5	3	8	16
Нойронд сэргэг болох	6	4	0	10
Эрч хүчтэй болох	0	1	0	1
Нойр хүрэх	0	3	4	7
Анхаарал төвлөрүүлэх чадвар буурах	0	0	6	6
Мансууруулах бодисын шартах хам шинжийн үед сэтгэцийн талаас илэрсэн шинж тэмдгүүд	Амфетамин	Амфетамин Каннабиноид Кокайн	Каннабиноид	N
Айдас түгшүүр төрөх	2	1	0	3
Хар дарж зүүдлэх	0	0	1	1
Сэтгэл санаа хямрах, уурлах	0	0	2	2
Сэтгэл санаагаар унах гутрах	0	0	1	1
Хий юм сонсогдох	0	1	0	1
Ядарч сульдах	0	1	5	6
Өөрчлөлт гараагүй	7	1	25	33
Мансууруулах бодис хэрэглэсэн хүний тоо	19	12	57	88

* Бидний судалгаагаар амфетамины төрлийн мансууруулах бодисыг дангаар нь хэрэглэсэн хүмүүст сэтгэн бодох чадвар сайжрах, нойронд сэргэг болох, сэтгэл өөдрөг болж хөөрч баясах зэрэг шинж тэмдгүүд голчлон илэрч байсан бол каннабиноидын төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн оролцогчдод тайвшрах, сэтгэл өөдрөг болж хөөрч баясах, нойр хүрэх шинж тэмдэг голчлон илэрч байжээ. Амфетамины төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн оролцогчдод анхаарал төвлөрүүлэх чадвар буурах шинж тэмдэг илрэхгүй байсан бол каннабиноидын төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн оролцогчдод нойронд сэргэг болох шинж тэмдэг илрээгүй байв. Дээрх шинж тэмдгүүд болон хэрэглэсэн мансууруулах бодисын төрөл нь статистик ач холбогдол бүхий (p=0.004) үзүүлэлттэй байлаа (Хүснэгт1).

Хэлцэмж: 2014 онд Монгол улсад олсны ургамал каннабисын тархац, нөөцийг тогтоох судалгаа хийхэд 14 аймгийн 49 сумын нутаг дэвсгэрт улсын хэмжээнд нийт 15000 га талбайд ургаж байгааг тогтоосноос үзэхэд[11] Монгол улсад каннабиноидын төрлийн мансууруулах бодисын хэрэглээ давамгай байгаа нь манай орны зарим нутаг дэвсгэрт зэрлэг олсны ургамал ихээр тархан ургадагтай холбоотой байх магадлалтай. Бидний судалгаанд 18-35 насны залуус, тэр дундаа оюутнууд зэрлэг олсны ургамал буюу каннабисыг өөрсдөө түүж бэлтгэн хэрэглэсэн байв. Энэ үр дүн нь оюутан залуучууд каннабиноидын төрлийн мансууруулах бодисыг хямд төсөр аргаар олж хэрэглэн мансуурч байгааг харуулж байна. Иймээс холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мансууруулах бодис агуулсан ургамлуудыг устгах ажлыг үр дүнтэй явуулах нь маш чухал гэж үзлээ.

Бидний судалгаанд хамрагдагсдын 78% нь 18-29 насныхан, 22% нь 30-41 насныхан, 35% нь оюутнууд байсан бол судлаач Ц.Вао-Ган, З.Хишигсүрэн нарын судалгаанд (2019) 20-29 насныхан 60.7%, 30-39 насныхан 23.8%, оюутнууд 21.4%-ыг эзэлж байлаа.[12] Бидний судалгаанд хамрагдагсдын 72% нь каннабиноидын мансууруулах бодисыг анх 25-аас доош насандаа хэрэглэж үзсэн байсан бол каннабисыг анх хэрэглэж үзсэн нас урлагийн сургуулийн оюутны хувьд 16.70 байхад бусад сургуулийн оюутнуудын хувьд 18.36 (p<0.001), анх архи уусан нас (15.56 ба 16.48% p<0.001), тамхи татаж эхэлсэн нас (16.96 ба 17.77% p<0.05) гэсэн нэгэн сонирхолтой судалгаа байна.[13]

Хэвлэлийн тоймоос үзвэл Либерид мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд хийгдсэн судалгаанд оролцогчид хүйсийн хувьд 65% нь эрэгтэй байсан бөгөөд насны хувьд 18-35 насныхан, үүний дундаж нас 25.7 (SD=5.0) байсан.[14] Турк улсад каннабисын хэрэглээний тархалтыг тогтоох судалгааг 8045 хүний дунд хийхэд тэдний 2.8% нь каннабисыг хэрэглэж үзсэн байсан бөгөөд каннабис хэрэглэгчдийн дунд түгшүүр (14%), хэрэглээгээ хянаж чадахгүй болох (14%), өдөр тутмын амьдралд каннабисын хэрэглээтэй холбоотой асуудал тулгарах (10.9%), хүн хоорондын хүчирхийлэл (6.9%) үүсдэг байна.[15] Хэвлэлийн тоймоос үзвэл Өмнөд Африкт 18-29 насны 904 залуучуудын дунд түргэвчилсэн тестээр шээсэнд сэтгэц идэвхит эм бодис илрүүлэх судалгаа хийхэд 32%-д архи, 52%-д каннабиниод, 22%-д амфетамин илэрсэн бөгөөд шээсэнд архи илэрсэн хүмүүсийн 61%, каннабис илэрсний 70%, амфетамин илэрсэн хүмүүсийн 48% нь бодис хэрэглэснийгээ хүлээн зөвшөөрсөн байна.[16]

Дүгнэлт:

1. Мансууруулах бодистой холбоотой ШСЭСМШ-нд хамрагдагсдын 83% нь мансууруулах бодис хэрэглэсэн бөгөөд тэдгээрийн 64.7% нь каннабиноид, 21.6 % нь амфетамины төрлийн мансууруулах бодис, 13.7% нь каннабиноид,

кокайн болон амфетамины төрлийн бэлдмэлийг хавсран хэрэглэсэн байсан ба 18-35 насны, гэр бүл болоогүй хүмүүс мансууруулах бодисыг түлхүү хэрэглэсэн байв.

2. Амфетамины төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн хүмүүст ой тогтоолт сайжрах, нойронд сэргэг болох, сэтгэл өөдрөг болж хөөрч баясах шинж тэмдэг илэрч байсан бол каннабиноид хэрэглэсэн хүмүүст тайвшрах, сэтгэл өөдрөг болж хөөрч баясах шинж тэмдэг тус тус голчлон илэрч байсан. Судалгаанд хамрагдагсдын 88.7% (n=94) нь сэтгэцийн хувьд эрүүл, 11.3% нь мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон.

Талархал: Бидний судалгааны ажилд чин сэтгэлийн туслалцаа үзүүлсэн СЭМҮТ болон ЦЕГ-ын ХТТГ-ын хамт олонд гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Бямбасүрэн С. Сэтгэцийн эмгэг судлал, 2-р хэвлэл. Улаанбаатар: Сэлэнгэпресс; 2019. х. 448-467*
2. *ЭМЯ, НЭМХ, СЭМҮТ, ДЭМБ. Мансууруулах эм бодис ба нийгмийн эрүүл мэнд. Улаанбаатар: 2016. х.11*
3. *Бямбасүрэн С. Мансуурал судлал. I хэсэг. Улаанбаатар: 1999. х. 4-5, 42-79.*
4. *Эрдэнэбаяр Л. Архидалт ба мансуурал. Улаанбаатар: Сэлэнгэпресс; 2015. х.123*
5. *United Nations Office on Drugs and Crime. World Drug Report 2016. Vienna: United Nations publication; 2016. p 9-10*
6. *United Nations Office on Drugs and Crime. World Drug Report 2020. Vienna: United Nations publication; 2020. p 7-8*
7. *Нийслэлийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл. Нийслэлийн өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хэрэглээ, ойлголтын талаарх тандалт судалгааны тайлан. Улаанбаатар: 2010. х. 5-8*
8. *ЗГХА-ЭМГ, НЭМГ, СЭМҮТ, ХТМБИХН. Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэгчдийн хэрэглээ, тэдний мэдлэг, хандлага, хор уршгийн талаарх тандалт судалгаа. Улаанбаатар: 2012. х. 4-5*
9. *Цагдаагийн ерөнхий газар. Хар тамхитай тэмцэх газрын дүн мэдээ. Улаанбаатар: 2018.*
10. *СЭМҮТ. Сэтгэцийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд. Улаанбаатар: 2018.*
11. *ХЗДХЯ, ЦЕГ, ХСИС. Хар тамхины гэмт явдал, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2018. х. 71-80*
12. *Вао-Ган Ц. Мансууруулах бодистой холбоотой сэтгэцийн эрүүл мэнд, хуулийн зарим асуудлууд. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.*
13. *Fruzsina Iszáj, Máté Kapitány-Fövény et al. Substance Use and Psychological Disorders Among Art and Non Art University Students: an Empirical Self Reporte Survey /Original article/. Int J Ment Health Addiction. 2018;16:125–135*
14. *Margaret L. Prust. Leslie Curry.Tamora A. Callands et al. Risk factors for and Consequences of substance use in post conflict Liberia: A qualitative study /Original paper/. Community Ment Health J. 2018; 54:438–449*
15. *Zeynep Kotan, Sevil Ozger Ilhan et al. Fundamental Characteristics, Attitudes and Behaviors Regarding Substance Use Focusing on Cannabis: Findings from the General Population Survey in Turkey, 2011 /Original paper/. Community Mental Health Journal. 2019; 55:709–713*
16. *Kodi B. Arfer, Mark Tomlinson, Andile Mayekiso et al. Criterion Validity of Self Reports of alcohol, cannabis, and methamphetamine use among young men in Cape Town, South Africa. Int J Ment Health Addict. 2018 February;16(1): 45–52*

Some mental health problems of offenders of drug-related crimes

Baigalimaa.S[1], Yumjirdulam.G[1], Gantsetseg.T[1]. Nasantsengel.Lkh[2]

[1]School of Medicine, MNUMS
[2]General director,NCMH

Background: The number of drug-related crimes, the number of accomplices and the amount of confiscated drugs are increasing year by year in neighboring countries, which may adversely affect our national security, rates of crime and public health and genetics. Therefore, we aimed to study the types of drugs which commonly used, some risk factors and their clinical manifestations.

Aim: To examine the drugs which are commonly used and the relation in crime of drug-related offenders who were screened for forensic psychiatry examination.

Material and method: The survey was conducted with cross sectional study design and data were collected by using questionnaires, specially designed tests, clinical examinations and documentary methods.

Results: Our study included 94 men and 12 women aged 18-41, for a total of 106 people, with an average age of 24.5±6.1. By age group, 90.6% were aged 18-35. According to 34 case files involving 106 participants, 83% of those surveyed tested positive for narcotic drugs and psychoactive substances in their urine. 88.7% (n=94) of the respondents were mentally healthy and 11.3% were diagnosed with drug-induced mental illness.

References: In our study, young people between the ages of 18 and 35, especially students, picked and used cannabis themselves. These results show that students and young people are becoming addicted to cannabinoids. Therefore, it is very important to implement the relevant legislation and effectively eradicate drug-containing plants.

Conclusion: It is important to educate children and young people about the dangers of drugs, as unmarried people between the ages of 18 and 35 are more likely to use drugs.

Key word: Cannabinoids, amphetamines, psychiatric condition